



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/596

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжаан Уйгарын Өөртөө засах орны Ардын Засгийн газар хамтран Үрэмч хотод зохион байгуулах Ажлын хэсгийн ээлжит хуралдаанд оролцох аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын зардалд 1 309 800 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1 309 800 /нэг сая гурван зуун есөн мянга найман зуун/ -ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/596 Ch  
02 02968

Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр  
сарын 17 -ны өдрийн А/596 дугаар  
захирамжийн хавсралт



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ, БҮГД НАЙРАМДАХ  
ХЯТАД АРД УЛСЫН ШИНЖААН УЙГАРЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ  
ОРНЫ АРДЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН АЖЛЫН  
ХЭСГИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Явах маршрут	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ/төгрөг/	Дүн /мян.төг/
1	Ховд- Булган боомт- Ховд /450*2 талдаа/	Литр	180	2510	451800
2	Томилолт /2019.09.17- 2019.09.20/	Хоног	3	700 юань *380=*3	798000
3	Дурсгалын зүйл	Ширхэг	2	30000	60000
Дүн:					1309800

-oOo-